

# Өмнөговь аймгийн хүн амын эрүүл мэнд, эмнэлгийн тусламж

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

*/2019 оны 8 сарын байдлаар/*

	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	Сумдын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Цэргийн анги	Нийт аймгийн дүн
1	Нийт үзлэг	79642	73702	50592	26867	2236	233039
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	31012	25017	16570	3095	1895	77589
3	Идэвхтэй хяналтын үзлэг	7617	14414	12577	1380		35988
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	21889	14505	8987	5791	322	51494
5	Нийт төрөлт	850	197				1047
6	Хэвтэн эмчлүүлэгчид	5496	3245		1676	20	10437
7	Нас баралт	31	124	78		1	234

1. Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 233039 хүнд үзлэг шинжилгээ хийсний 48,7%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
2. Ортой эмнэлгүүдэд нийт 10437 хүнийг 68108 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.5 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
3. 8 сарын байдлаар 45548 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9264 тохиолдлоор өссөн байна.
4. Эхний 8 сарын байдлаар 826 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 45 хүн нас барсан нь өнгөрсөн оноос өвчлөл 123 тохиолдлоор буурч, осол гэмтлийн нас баралт 12-р тохиолдлоор өссөн байна. Осол гэмтлээр нас барагсдын 28.8%/13/нь амиа хорлож/Бд-1,Гт-2,Мо-1,Мн-3,Но-1,Сэ-1,Хх-1,Хб-1,Эу-2/ 37.7%/17/нь зам тээврийн осол,/Бо-1,Но-3,Нн-1,Сэ-1,Хб-2,Хү-2,ЦЦ-1,Эх-1,Эу-1,БОЭТ-4/, 28,8%/13/ нь бусад ослоор/хөлдсөн-8-Сэ-2,Хб-1,Хх-1,Цц-2,Шб-1,Эх-1,архины хордлого-Бд-1,Гт-2,Эх-1,зодуулсан-Но-1/ 6,6%/2/бусдад хорлогдсон-/Но-1/,Хб-1/ тус тус эндсэн байна. Осол гэмтлээр нас барагсадын 77.7% нь эрэгтэй хүмүүс эндсэн байна. Мөн ослоор эндэгсдийн 77.7% нь эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүйн дээр эмнэлэгт нас барсан 60%/10/ хүний /зам тээврийн ослоор-4, хөлдсөн-1, өөрийгөө хутгалсан-1 нийт-6 хүн/хүнд гэмтлийн улмаас хоног болоогүй нас барсан байна. Нийт осол гэмтлийн нас баралт:Бд-2/амиа хорлосон-1,архины хордлого-1, Бо-1/зам тээврийн осол-1,Гт-4/амиа хорлосон-2,хөлдсөн-1,зам тээврийн ослоор-1/,Мо-1/амиа хорлосон-1/,Мн-3/амиа хорлосон-3/,Но-4/зам тээврийн осол-3,амиа хорлосон-1/,НН-1/зам тээврийн осол-1/,Сэ-4/хөлдсөн-2,амиа хорлосон-1,зам тээвэр-1/,Хх-2/амиа хорлосон-1,хөлдсөн-1/,Хб-5/амиа хорлосон-1,хөлдсөн-1,бусдад хорлогдсон-1,зам тээрийн осол-2/,Хү-2/зам тээврийн осол-2/,ЦЦ-1/зам тээврийн осол-1/шим билэг-1/осгосон-1/, Эх-3/архинд хордсон-

- 1,хөлдсөн-1, зам тээврийн осол-1//Эу-5/амиа хорлосон-2,зам тээвэр-1, хөлдсөн-2/БОЭТ-6/бусдад хорлогдсон-1,зам тээвэр-4,юманд цохигдсон-1/
5. Оны гарсаар 234 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 19.2% нь осол гэмтлээр, 26% нь хорт хавдраар 6.4% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт/Бо-1,Но-1,Хх-4,Цо-1,Шб-2,Өо-2,Эх-2,Цц-1,Эу-1/ зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 7,7% /Бд-1,Хб-6,Гт-3,Мн-1,Нн-2,Цц-1,Шб-3,Бг-1/нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна.
  6. Нялхсын эндэгдлийн 23/Бд-1,Гт-4,Хб-7,Цц-2,Мн-1,Хү-1,Шб-3,Эх-1,Бг-1,Нн-2,/тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 21,8 байна.
  7. Түргэн тусламжийн 8270 дуудлагад явж үйлчилсний 1207/14.6%/ нь алсын дуудлага, 477/5,7%/ нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 96% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна .
  8. 8 сард 4361 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 63.1% эзэлж байгаа нь хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 9 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,2%-г эзэлж байна.
  9. Нийт 1047 эх төрж 1051 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 54 төрөлтөөр хүн амын төрөлт өссөн байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна. Нийт төрөлтийн 5,5% охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна./Бд-1,Бо-2,Бу-2,Гт-3,Мн-3,Но-3,НН-1,Сэ-2,Хб-1,Хх-3,Хү-1,Цц-4,Шб-9,Өо-14,Эх-5,Бг-3/.
  10. 8 сарын байдлаар 516 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 491 байгаа нь өнгөрсөн оноос 2,4% буурсан үзүүлэлт байна.Өсвөр насны охидын үр хөндөлт 5,2%/Бд-1,Бу-3,Мо-1,Мн-1,Но-2,Нн-1,Сэ-1,Хб-4,Хх-2,Хү-1,Цц-1,Шб-4,Өо-2,Эх-3,Б/г-2/ байна.
  11. Он гараад 361 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 109 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 14,1%-г салхинцэцэг, 6,3%-г улаанэсэргэнэ өвчин, 25,2%-г хоолны хордлого, 38%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
  12. ЭЭСангуудад нийт 11880 жор ирсний 49,4%/5871/нь ЭМДаатгалын, 0,1%/11/ мансууруулах эмийн, 2% /233/ сэтгэц нөлөөт эмийн, 48,5% /5765/ нь энгийн эмийн жор байсан ба 1,1% /131/нь алдаатай жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 72,3% байна.
  13. БОЭТөвд 31 эндэгдэл тохиолдож 8 эндэгдэлийг онош тодорхой, өндөр настан, ар гэрийн хүсэлтээр гэсэн шалтгаанаар задлан шинжилгээнд хамруулаагүй ба задлан шинжилгээний хувь 74,1% тай байна. Үндсэн оношийн зөрөө 2%.